



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 1/539

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 2.4.1.5, 2.4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж “Өв-Агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК-д тариалсан ногоон тэжээлийг хураах шатахууны зардалд 22,692,000 (хорин хоёр сая зургаан зуун ерэн хоёр мянга), ногоон тэжээлийн мяндасны үнэ 7,800,000 (долоон сая найман зуун мянга), тракторын сэлбэг засварт 5,000,000 (таван сая) төгрөг, нийт 35,492,000 (гучин таван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга) төгрөгийг тус тус хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд тусгагдсан 35,492,000 (гучин таван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү 35,492,000 (гучин таван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга) төгрөгийн зардлыг өөрийн тариалж, хураан авсан малын тэжээлээр эргүүлэн төлж, аймгийн өвс, тэжээлийн агуулахад 3550 боодол ногоон тэжээлийг төвлөрүүлэхийг “Өв-Агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК (Р.Намгилрагчаа)-д даалгасугай.

4. Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

6223 11 1075

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 30-ны өдрийн 11539 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРЬ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Дизель түлш	литр	6200	3,660	22,692,000
2	Мяндас	боодол	60	130,000	7,800,000
3	Сэлбэг				5,000,000
Нийт дүн					35,492,000

-оОо-